

## АЧАА ООСОРЛОХ ХЭРЭГСЛИЙГ ГОЛОГДОЛД ГАРГАХ НОРМ

Татлагат тэнжээний татлагын гадна байрлах утсуудын тасралтын тоо хүснэгтэнд зааснаас их байвал гологдолд гаргана.


Хүснэгт

Татлагат тэнжээ /давхар эрчтэй/	Татлагат тэнжээний уртын дагуу тасарч, ил гарсан утасны тоо		
	3d	6d	30d
	4	6	16

**Тайлбар** d-татлагын голч, /мм/

Гинжит тэнжээ элэгдэлд орсны улмаас анхны хэмжээнээсээ гинжний үеийн урт нь 3%-иас их болсон, хөндлөн огтлолын голчийн хэмжээ нь 10%-иас илүү багассан тохиолдолд гологдолд гаргана.

$$L_1 \leq L_0 + 3\% L_0$$




Зураг1

Гинжний уртассан үе:

$L_0$ - гинжний үеийн анхны хэмжээ, /мм/

$L_1$ - гинжний үе уртассан хэмжээ, /мм/

$$\frac{d_1 - d_2}{2} \geq 0.9 d_0$$



Зураг2

Гинжний үеийн хөндлөн огтлолын нарийссан голчийн хэмжээ:

$d_0$ - үеийн анхны голч хэмжээ, /мм/

$d_1, d_2$ - үеийн элэгдсэн голчийг харилцан перпендикуляр чиглэлд хэмжээ, /мм/